



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/23

Улаанбаатар хот

Оны тэргүүний байгууллага, салбар,
нэгжийг шалгаруулах, шагнаж урамшуулах тухай

“Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйл, “Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2 дахь заалт, Газрын даргын 2023 оны А/257 дүгээр тушаалаар батлагдсан “Ус цаг уур, орчны хяналт шинжилгээ, мэдээлэл үйлчилгээний ажлыг дүгнэх журам”, 2017 оны А/08 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Нэгтгэн дүгнэх журам”, 2020 оны “Журамд өөрчлөлт оруулах тухай” А/12 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний салбарын 2024 оны нэгдсэн дүнг 1 дүгээр хавсралтаар баталж, Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийг нэгдүгээр байрт, Дархан-Уул аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийг хоёрдугаар байрт, Орхон аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийг гуравдугаар байрт тус тус шалгаруулж өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнасугай.

2. Цаг уурын шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний 2024 оны ажлын үр дүнг үндэслэн Ховд аймгийн “Манхан”, Увс аймгийн “Хар-ус”, Завхан аймгийн “Тосонцэнгэл” өртөөдийг “2024 оны тэргүүний өртөө”-гөөр, Завхан аймгийн “Завхан - бороо” экспедиц, Говь-Алтай аймгийн “Алтай - бороо” экспедицүүдийг “2024 оны тэргүүний тунадас нэмэгдүүлэх экспедиц”-ээр, Дорнод аймгийн Байгаль орчны шинжилгээний лаборатори, Хэнтий аймгийн Байгаль орчны шинжилгээний лабораториудыг “2024 оны байгаль орчны шинжилгээний тэргүүний лаборатори”-оор тус тус шалгаруулж, өргөмжлөл олгосугай.

3. Шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний 2024 оны ажлын үр дүнг үндэслэн Орхон аймгийн “Улаантолгой”, Өвөрхангай аймгийн “Баянгол”, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ харуулуудыг “2024 оны тэргүүний цаг уурын харуул”-аар, Өвөрхангай аймгийн “Онги-Уянга”, Архангай аймгийн “Хойд тамир-Их тамир”, Булган аймгийн “Сэлэнгэ-Хутаг” харуулуудыг “2024 оны тэргүүний ус судлалын харуул”-аар тус тус шалгаруулж өргөмжлөл олгосугай.

4. Нислэгийн цаг уурын мэдээлэл, үйлчилгээний 2024 оны ажлын үр дүнг үндэслэн тогтмол нислэгтэй аймгуудаас Ховд аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийг, тогтмол нислэггүй аймгуудаас Өвөрхангай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийг, нисэх буудалгүй аймгуудаас Говьсүмбэр аймгийн

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийг тус тус “2024 оны нислэгийн цаг уурын үйлчилгээ үзүүлсэн тэргүүний хамт олон” - оор шалгаруулж өргөмжлөл олгосугай.

5. Ажлын үр дүнгээр тэргүүлсэн байгууллага, салбар нэгжүүдэд олгох шагнал, дагалдах техник хэрэгслийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

6. Оны тэргүүний өртөө, харуул лаборатори, нислэгийн үйлчилгээ, экспедицээр шалгарсан салбарын албан хаагчдад ажлын гүйцэтгэлийн үнэлгээг харгалзан нэг сарын үндсэн цалин хүртэлх хэмжээний мөнгөн урамшууллыг цалингийн сандаа багтаан нэг удаа олгохыг тухайн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга нарт зөвшөөрсүгэй.

7. Оны тэргүүний төвөөр шалгарч нэгдүгээр байр эзэлсэн Өвөрхангай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга /Ч.Чанцалдиймаа/-д нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг, хоёрдугаар байр эзэлсэн Дархан-Уул аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга /С.Алтандолгион/-д нэг сарын үндсэн цалингийн 70 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг, гуравдугаар байр эзэлсэн Орхон аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга /С.Отгонбаатар/-д нэг сарын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг тус тус нэг удаа олгохыг тухайн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Ахлах нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

8. Оны тэргүүний тунадас нэмэгдүүлэх экспедицээр шалгарсан Говь-Алтай аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга бөгөөд экспедицийн зохицуулагч /Н.Алтантуяа/-д нэг сарын үндсэн цалин хүртэлх хэмжээний мөнгөн урамшуулал нэг удаа олгохыг тухайн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Ахлах нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

9. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, аудитын хэлтсийн дарга Р.Бадмаадоржид даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,
УРЬДЧИЛАН МЭДЭЭЛЭХ
ХЭЛТСИЙН ДАРГА



Л.ОЮУНЖАРГАЛ